

ХАЛХЫН ГОЛЫН ДАЙНЫ БАЯНЦАГААНЫ ТУЛАЛДААНЫ
ТАЛААР НЭХЭН ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Д.Дашдулам.

Монгол улсын их сургууль, Нийгмийн шинжлэх ухааны сургууль. Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Монголын зүүн хязгаарт дөрвөн сар гаруй хугацаанд Монгол, Япон, Зөвлөлтийн цэргийн томоохон хүч оролцсон дайн болсон юм. Уг дайнд бүх төрлийн цэргийн хүч оролцсон ширүүн тулалдаан болсон төдийгүй Дэлхийн II дайны түүхэнд онцгой байр эзэлдэг юм. Халхын голын дайны түүхэнд VII сарын тулалдаан буюу Баянцагааны тулалдаан нь дайны явцад эргэлт гаргасан юм. Баянцагааны тулалдаанд Монгол-Зөвлөлт болон Японы тал ихээхэн цэрэг техник хуримтлуулан байлдсан бөгөөд Японы цэрэг Халхын голыг эхний бөгөөд сүүлчийн удаа гаталсан юм. Баянцагааны тулалдаанд Монгол-Зөвлөлтийн хамтарсан хүч ялалт байгуулсан явдал нь дайны түүхэнд эргэлт гаргахад нөлөөлсөн юм.

Түлхүүр үг: Халхын гол, Баянцагааны тулалдаан, Г.К.Жуков, М.П.Яковлев, И.И.Федонинский, Комацубара, Ясуока, Квантуны арми, “танк устгах бүлэг”, армийн I бүлэглэл

Халхын голын дайн нь Монгол улсын түүхэнд онцгой байр эзэлдэг төдийгүй ОХУ, Японы түүхэнд ч тодорхой байр суурь эзэлдэг юм.

Хэдийгээр дайн дуусаад далан жил өнгөрсөн ч дайн үүссэн шалтгаан, зорилго, мөн чанар, явц, үр дүн зэрэг олон асуудал зөвхөн гурван улсын төдийгүй дэлхийн олон орны судлаачдын анхаарлыг татсан хэвээр байна.

Монгол дахь Халхын голын дайны талаарх судалгаа 1990-ээд оны эхэн үеэс шинэ шатанд гарч, асуудлыг олон талаас бодиттойгоор хандан, бүс нутаг болон олон улсын харилцааны нөхцөл байдалд уялдуулан авч үзэх болсон нь томоохон дэвшил юм.

Үүний хүрээнд дайнд оролцогч талууд Монгол, Орос, Японы судлаачид Халхын голын дайны талаар хамтран судалгаа хийж, санал бодлоо солилцон, мэтгэлцэх болсон нь судалгааны чанар, агуулгыг шинэ, өндөр түвшинд гаргасан юм*.

Дайны түүхийг судлахад дайн эхэлсэн болон үргэлжилсэн хугацаа, байлдааны ажиллагааны газар орон, өрсөлдөгч талуудаас оролцсон хүн хүч, техник, зэвсэглэлийн хэмжээ, байлдах урлаг, үе шат, үр дүн, сургамжийг тодорхой харгалзах шаардлагатай юм.

XX зууны Монголын зэвсэгт хүчний түүхэнд томоохон байр эзэлдэг Халхын голын дайны талаар тэр дундаа улсын болон Баянцагааны тулалдааны талаар тогтож өгүүлье.

Уг тулалдааныг түр бичлэгт “Баянцагааны тулалдаан”¹, “Баянцагааны байлдаан”², “Халхын голын зүүн эргийн түшиц газрыг хамгаалсан байлдааны үе”³ гэх зэргээр нэрлэдэг юм.

1939 оны V сард болсон тулалдааны үр дүнг Москва, Токио маш анхааралтай судлан шинжилж, томоохон операцид аль, аль нь бэлдэж байлаа.

Оросын тал байдлыг газар дээр нь судалж, шаардлагатай арга хэмжээг авахуулахаар Белоруссын цэргийн тойргийн командлагчийн орлогч, дивиз командлан захирагч Г.К.Жуков нарыг V сарын 24-нд илгээх шийдвэр гарч⁴ V сарын сүүлээр Монголд иржээ. Тэрбээр Монголын зүүн хязгаар дахь үйл явдал мөргөлдөөн бус харин шатлан

*1989 оноос Монгол, Орос, Японы судлаачид зургаан удаа хамтарсан хурлыг Улаанбаатар, Москва, Токио хотод зохион байгуулсан.

¹ Ц.Батбаяр, Халхын гол түүх ба орчин үе

² Б.Доржсүрэн, Түүхэн ялалтын уг сурвалж, ач холбогдол, УБ., 1989, 36 дахь тал

³ Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, эрдэм шинжилгээний бага хурлуудын эмхтгэл, №2, УБ., 2006, 89 дэх тал

⁴ Халхын голын дайн: нэгэн жарны тэртээд, УБ., 1999, 107 дах тал

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

өргөжих цэрэг, дайны ажиллагаа гэж үзээд одоо байгаа 57-р онцгой корпусын хүчээр дайсны халдлагыг няцаах боломжгүй гэж үзжээ.⁵

Квантуны армийн хувьд Халхын голын зүүн эрэгт хориглож буй Монгол-Зөвлөлтийн цэргийн бүлэглэлийг зүүн талаар тойрон ороож, Халхын голыг гатлан, Баянцагааныг эзлэн, хойд зүг давшиж, Монгол, Зөвлөлтийн цэргийг ар талаас нь бүслэн цохих бэлтгэлийг базааж байв. Үүний тулд хошууч генерал Кобаяшигийн анги Баянцагааныг эзлэн төв фронтоор давших генерал Ясуокагийн нэгтгэлтэй харилцан уялдаж довтлох төлөвлөгөөтэй байв.

Дэслэгч генерал Комацубарагийн удирдсан 23-р дивиз Хайлаараас VI сарын 20 ноос хөдөлж 26-29-ний хооронд заагдсан бүсэд төвлөрч дуусчээ.

Түүний мэдэлд шинээр томилж ирүүлсэн 7-р дивизийн 26, 27-р хороо, их бууны 1-р хороо, явган цэргийн 64-р хороо, механикжуулсан 4-р хороо, танкийн 3, 4-р хороо, 71, 72-р их бууны хороо, инженерийн ангиуд зэрэг 3600 хүн, их хүчийг хуримтлуулжээ.

Энэ бүлэглэлд нийтдээ 38 мянган цэрэг офицер, 310 их буу, 135 танк, 10 хуягт машин 225 нисэх онгоц ордог байв.⁶

Дэслэгч генерал Комацубарагийн баруун зүүн чиглэлд хошууч генерал Кобаяши Коичи, дэслэгч генерал Ясуока Масаоми нар тулалдахаар болжээ.⁷

Кобаяшигийн групп тохирсон ёсоор VII сарын 1-ний үүрээр Жанжин сүмээс хөдлөн 2-ны шөнө Хуруу өндөрлөгийн орчмоор Халх голыг гатлах ёстой байв.

Халхын голыг гатлах асуудал их төвөгтэй байв. Учир нь 50 метр өргөнтэй гэж тооцоолж байсан боловч бороо их орсоны улмаас өргөн нь 60-100 метрт хүрч, голын гүн 2 метрээс илүү болжээ.⁸

Халхын голыг гатлахын тулд хөвдөг гүүр тавих ажлыг инженерийн 23-р нэгтгэлийн дарга, дэд хурандаа Сайто Исаму удирдан явуулжээ.

Гүүр тавих ажил нь их удаашралтай явагдаж байв. Энэ нь тухайн нөхцөл байдлын талаарх мэдээлэл хомс, ширүүн урсгал, өндөр эрэг, хүйтэн зэргээс болж байсан төдийгүй Орос-Японы дайны үед хэрэглэж байсан хөвөгч гүүр (пантон) нь хүнд бөгөөд тээвэрлэхэд бэрхшээлтэй байжээ.⁹

Япончуудыг гол гатлан Баянцагаанд ирсэнийг Зөвлөлт, Монголын командлал мэдмэгц голын баруун эрэгээс яаралтай шахах, төлөвлөгөө боловсруулжээ.

М.П.Яковлевын командалсан 11-р танкийн бригад, И.И.Федюнинскийн 24-р мотобуудлагын хороо, Монголын ардын хувьсгалт цэргийн 6,8-р морьт дивизүүд өдөржин, шөнөжин ширүүн тулалдаж байв.

Япончууд Баянцагаанд 5 км өргөн, 2 км гүн хориглолтын зурваст бүх хүчээрээ хамгаалан дайтаж байлаа.¹⁰

Тэд танк, хуягттай тулалдахдаа “танк устгах бүлэг”-үүдийг өргөнөөр ашиглаж байв. Тэдний “амьд сум” нь шатах буюу тэсрэх бодис шидэх эсвэл танкан дээр гарч, дотор нь шиддэг байжээ. Энэ аргаараа 20-30 минутын дотор 10 танкийг устгах буюу жагсаалаас гаргаж байлаа.¹¹ Мөн “амьд сум”-ын талаар ЗСБНХУ-ын Батлан хамгаалах ардын комиссарын орлогч Куликээс VII сарын 3-12-нд болсон байлдааны дүнг Батлан хамгаалах ардын комиссарт илтгэсэн илтгэлдээ: “Японы явган цэрэг нь хэт шүтлэгтэй, сайн бэлтгэгдсэн, ялангуяа шөнийн ажиллагаанд бэлтгэлтэй, тагнуул явуулж зай завсрыг олж

⁵ Жуков, Г.К. Дуртгал бодол. 1-р боть, УБ., 1997. 170-171 дэх тал

⁶ Новиков. М. Победа на Халхин-голе, М., 1971., с.49. vol.1, p.290

⁷ А.Д.Соох. Nomonhan. vol.1. p.290

⁸ А.Соох, Nomanhan, vol.1, p.85

⁹ А Соох, Nomonhan, vol.1, p.95

¹⁰ Монгол цэргийн түүхийн товчоон, УБ, 1996, 307 дах тал

¹¹ А.Соох, Nomankan. Vol.1, p.301-302

чаддаг байна. Танк сөнөөх бүлгүүд нь онцгой сайн ажилладаг. Үхэх тавилантай энэ хэт шүтлэгтнүүд манай танкуудыг их сөнөөлөө”¹² хэмээжээ.

Дайны талбарт Япон цэргүүдийн амиа золих явдал эзэн хаан, эх орондоо үнэнч байгаагийн илэрхийлэл, эр зориг баатарлагын туйл болон гайхагдсан бол Номхон далайн дайны үед онгоцны нисэгч нарын тусгай бэлтгэгдсэн салаа сөрөг талынхандаа ихээхэн хохирол учруулдаг байсан юм.

VII сарын 3-4-ний тулалдаан тун ширүүн болсон бөгөөд Монгол-Зөвлөлтийн хамтарсан хүчний давших ажиллагаа эрчимжихийн хирээр хоёр тал их хохирол амсаж байлаа.

Квантуны армийн удирдлага VII сарын дунд үеэс хойш хийсэн давших тулалдаанууд нэгэнт амжилтгүй болсон тул тактикаа өөрчлөн хориглох тулаанд бэлдэж, хүчээ сэлбэн шинэ давшилтанд бэлтгэх болсон юм.

Халхын голын VII сарын тулалдаан аль, алинд нь ч хүндхэн сорилт болсон бөгөөд Японы тал анхны бөгөөд эцсийн удаа Халхын голыг гаталсан юм. Байлдааны ажиллагаанд Квантуны цэргийн командлалаас тооцож үзээгүй зарим зүйлүүд бэрхшээлийг учруулж байлаа. Цэргийн хоол хүнс, сум хэрэгсэлээс гадна уух цэвэр усны асуудал хамгийн ноцтой зүйл байлаа. Мөн VII сарын аагим халуун, Халхын голын шумуул ч түүнээс дутахгүй сэтгэл санааны хохирол учруулж, бие бүрэлдэхүүнд муугаар нөлөөлж байжээ. Мөн олон шөнө, өдөр тасралтгүй байлдаж Баянцагааны зүүн хэсэгт цэргүүд нь хэдэн мянгаараа алагдсан явдал ч бас нөлөөлсөн юм.

Баянцагааны тулалдаанд япончууд бүслэгдэн бут цохигдоод зугатахдаа Халхын голын дээд урсгалаар халдварт бактерийг хаяж, усыг хордуулж байжээ.

Монгол, Зөвлөлтийн цэрэг Квантуны армийн төлөвлөгөөг тасалдуулж бүслэн, довтолж VII сарын 13-наас Халх голоос ухрааж давших тулалдаанд оржээ.¹³

VII сарын тулалдаан нь зөвлөлтийн армийн түүхэнд болон байлдах урлагт хэд хэдэн чухал зүйлийг үлдээсэн юм. Урьд өмнө хаана ч болж байгаагүй цэргийн хүчийг хуримтлуулан агаарын, явган болон морьт цэрэг, танк, моторжуулсан хуягт ангиудыг оролцуулан байлдааны ажиллагааг явуулсан байдаг. 1938 оны Хасан нуурын төлөөх тулалдаанд ч ийм их хүчийг хоёр талаас оролцуулаагүй юм.

Мөн цэргийн анги салбаруудыг довтлон хориглох, давших, бүслэн хаах зэрэг тактикийг боловсруулан хэрэгжүүлэх туршлага хуримтлуулсан нь хожмын Германтай хийх дайнд ихээхэн хэрэг болсоныг тэмдэглэх хэрэгтэй. Үүнд, Ялангуяа зөвлөлтийн армийн нэрт жанжин Г.К.Жуков онцгой үүрэг гүйцэтгэсэн юм. Ялангуяа зөвлөлтийн арми шөнийн байлдаан хийх чадвар хангалтгүй болон салбар, анги нэгтгэл, командлалын байлдааны үед удирдлагаар хангах, нөхцөл, чадварыг нэмэгдүүлэх, их буу явган цэрэгтэй харилцан ажиллах болон нисэх онгоц, их буу, танк зэргийг яаравчлан шинэчлэх зэрэг шаардлагатайг мэдэж, туршиж авсан юм.

Тиймээс Баянцагааны тулалдааны талаар ЗСБНХУ-ын Батлан Хамгаалах ардын комиссарын орлогч, армийн I зэргийн командлагч Куликээс Халхын голд байлдаж буй армийн нэгдүгээр бүлгийн ангиудын бэлтгэл, байлдааны ажиллагааны явцыг шалгаад акт гаргасан байдаг.¹⁴

Уг актанд байнгын ангиуд, хуягт болон тактикийн ангиуд, нисэх хүчин, удирдлага хэрхэн байлдсан талаар харьцуулан шинжилж, цаашид анхаарах зүйлийн талаар дэлгэрэнгүй заажээ. Мөн байлдааны бэлтгэлийг хэрхэн хангах харилцан ажиллагааг зохион байгуулах талаар дүгнэлт өгсөн байдаг.

Халхын голын дайны явцад дайтагч хоёр талын аль аль нь хүн хүч, зэр зэвсэгийг бүхий л бололцоогоо ашиглан зохион байгуулж хуралдуулсан бөгөөд VII сарын тулалдаан

¹² Халхын голын дайн: нэгэн жарны тэртээд. УБ, 1999, 146 дахь тал

¹³ Халхын голын дайн, нэгэн жарны тэртээд, УБ., 1999, 154 дэх тал

¹⁴ Мөн тэнд. 162-179 дэх тал

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

маш ширүүн болж өнгөрсөнийг хэлэх хэрэгтэй. Тэдний аль аль нь ч ялгаагүй цэргийн урлагийн түүхэнд анхны гэсэн зүйл олон байсан аж. Тиймээс ч дайны явцад ялалт байгуулах уу, ялагдах уу гэдгийг шийдвэрлэх тулалдаанууд чухамдаа VII сард болсон юм. Дөрвөн сар үргэлжилсэн дайны явцад нийт 101 томоохон тулалдаан болсоны хамгийн олон нь буюу 32 удаагийн тулалдаан VII сард болжээ.¹⁵

Өнгөрсөн хугацаанд тулалдааны явц хохирол, үр дүнгийн талаарх судалгааны ажил нилээд хийгдсэн ч гэлээ дайнд оролцсон улсуудын судлаачид хамтран цаашид гүнгийрүүлэн судлах шаардлага зайлшгүй гарч байгааг зориуд тэмдэглэх хэрэгтэй болов уу. Үүний тулд гурван улсын архивын сан хөмрөгт байгаа материалуудыг харьцуулан судлах, газар орон, хүний нэр, тулалдаан болсон өндөрлөгүүдийг тодорхой болгох, тулалдаануудыг цэргийн болон техникийн урлаг талаас судлан цэргийн онцлог байдлыг тодруулах, ялангуяа Монгол, Орос, Япон цэргүүдийн сэтгэл зүйн байдал, төлөвшил, онцлог, ёс суртахууны хэв шинж, дайны нөхцөл байдалд илрэх хандлагын талаар цаашид нухацтай судлах хэрэгтэй байна.

¹⁵ Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн. Эрдэм шинжилгээний бага хурлуудын эмхтгэл, УБ, 2006, 92 дах тал